



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 2021

Арвайхээр

Аймгийн 2023 оны цэрэг татлагын товчоо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн хэмжээнд 2023 оны цэргийн жинхэнэ албаны халалт, татлагыг удирдан зохион байгуулж ажиллах “Цэрэг татлагын товчоо”-г дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын Дарга: Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Орлогч дарга: М.Дэлгэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)

Гишүүд: А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Г.Чимэддагва (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)

Б.Чимэддорж-Ойдов (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Т.Нарангарав (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Шивааннурдэв (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга)

Д.Одонбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)

Г.Дашжанцан (аймгийн Бүсийн оношилогоо, эмчилгээний төвийн дарга)

Нарийн бичгийн дарга: Ч.Ванчинсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн ахлах офицер, дэд хурандаа)

6223 11 0374

D:My Doc. Zahiramj. Zasag darga

6.1	Хүнс, хөдөө аж ахуй	Ургамал, газар тариалан хамгаалах бүлэг	Хүнс, хөдөө аж ахуйн газар
6.7	Мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх ажиллагаа	Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн бүлэг	Мал эмнэлгийн газар
		Ариутгал халдварт өвчинтэй тэмцэх ажиллагаа	
Долоо. Эрчим хүчний алба			
7.1	Цахилгаан хангамж	Цахилгаан шугам сүлжээний засварын бүлэг	ЭБЦТС, ТӨХК-ний салбар
Найм. Зам тээврийн алба			
8.1	Зам, гүүрийн засвар үйлчилгээ	Зам, гүүрийн засварын бүлэг	“ӨВ АЗЗА” ТӨХК
8.2	Тээврийн хангалт	Тээврийн бүлэг	Авто тээврийн төв
Ёс. Мэдээлэл, харилцаа холбооны алба			
9.1	Харилцаа холбоо, зарлан мэдээлэл	Харилцаа холбоо, зарлан мэдээллийн бүлэг	Мэдээлэл холбоо, сүлжээ ТӨХК
			Монголын цахилгаан холбооны Өвөрхангай аймаг дахь Холбооны газар
Арав. Сурталчилгааны алба			
10.1	Мэдээлэл сурталчилгаа	Мэдээлэл сурталчилгааны бүлэг	Монголын сэтгүүлчдийн холбооны Өвөрхангай аймаг дахь салбарын тэргүүн
			Аймгийн ЗДТГ-ын Хэвлэл мэдээллийн ажилтан
Арван нэг. Иргэний бүртгэл мэдээлэл, статистик судалгааны алба			
11.1	Иргэний бүртгэл мэдээлэл, статистик судалгаа	Иргэний бүртгэл мэдээллийн бүлэг	Улсын бүртгэлийн хэлтэс
		Статистик мэдээллийн бүлэг	Статистикийн хэлтэс
Арван хоёр. Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба			
12.1	Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх	Цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх бүлэг	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
		Байгалийн аюулыг үнэлж мэдээлэх бүлэг	Ус цаг, уур орчны шинжилгээний газар
Арван гурав. Бусад			
13.1	Гал түймэр унтраах ажиллагаа	Гал түймэр унтраах бүлэг	Гал түймэр унтраах, аврах 12, 45 дугаар анги
13.2	Инженер, тэсэлгээ	Инженер, тэсэлгээний бүлэг	Зэвсэгт хүчний 256 дугаар анги
13.3	Нисэх буудлын аюулгүй байдал	Нисэх буудлын аюулгүй байдлын бүлэг	Нисэх буудал

2. Аймгийн цэрэг татлагын товчооны дарга, орлогч даргад ДААЛГАХ нь:

а) Цэрэг татлагын товчооны гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоож, цэрэг татлагын ажилтай холбоотой хууль, эрх зүйн баримт бичиг, тухайн ажлыг гүйцэтгэх онцлогийн талаар зааварчилгаа өгч, бусад зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах;

б) Цэргийн жинхэнэ албаны татлагын ажлыг сайтар зохион байгуулж, “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ыг баримтлан иргэдийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн татаж, Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн хяналтын тоог биелүүлэх;

в) Цэрэг халалт, татлагын ажлын явцад байнгын хяналт тавьж, цэрэг татлагын товчооны үйл ажиллагаатай холбогдуулан иргэдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдлыг цаг тухайд нь хуулийн дагуу шийдвэрлэж ажиллах;

г) Засгийн газрын 2018 оны 11 дүгээр тогтоол “Цэргийн гэрээт алба хаах журам”, 2018 оны 80 дугаар тогтоол “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ын талаар сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах, цэргийн гэрээт албанд орох хүсэлт гаргасан иргэний асуудлыг харьяа цэргийн ангид нь уламжилж шийдвэрлүүлэх;

д) Цэргийн жинхэнэ албанд татагдсан иргэдийн хувийн бичиг баримтын зөрчлийг урьдчилан арилгаж, иргэний үнэмлэхгүй, бичиг баримтын зөрчилтэй иргэнийг цэргийн албанд татахгүй байх;

е) Цэрэг татлагын ажлын дүн мэдээг 2023 оны 05 дугаар сарын 10-ны дотор Зэвсэгт хүчний Жанжин штабт өгөх, 2023 оны 4 дүгээр улиралд цэрэг татлагыг зохион байгуулж явуулсан дүнгийн талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсролын талаар хэлэлцүүлж цаашид авах арга хэмжээг тодорхойлох;

3. Цэрэг татлагын товчооны гишүүдэд ДААЛГАХ нь:

а) Цэрэгт татагдагчдад эрүүл мэндийн үзлэг явуулах нарийн мэргэжлийн эмч, сувилагч нарыг томилон холбогдох зааварчилгааг өгч, шаардлагатай байр, эм эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннурдэв), Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн дарга (Г.Дашжанцан) нарт;

б) Цэрэг татлагын байранд мэргэжлийн байгууллагаар өдөрт 2-с доошгүй удаа ариутгал, халдвартайжүүлүүлэлтийг хийж, эрүүл мэндийн газраас мэргэжлийн албан тушаалтан томилж хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннурдэв), Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Одонбаяр) нарт;

в) Мансууруулах бодисын хамааралтай, энэ төрлийн эм, сэтгэцэд нөлөөлэх бодис, тэдгээрийн түүхий эдийг хэрэглэдэг донтой нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон иргэдийн судалгаа гаргаж, цэргийн албанд татахгүй байхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа М.Дэлгэрсайхан), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Г.Чимэддавга), аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннурдэв) нарт;

г) Цэрэг татлага эхлэхээс өмнө сурьеэгийн сорил тавих, өвчилж болзошгүй болон сурьеэгийн ойрын хавьтальтай цэргийн насны залуучуудын судалгаа гаргаж, цэргийн албанд татахгүй байхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

(хурандаа М.Дэлгэрсайхан), аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннүрдэв) нарт;

д) Сумдад цэрэг татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, зарлан дуудах мэдэгдэл авсан боловч тогтоосон хугацаанд цэрэг татлагын байранд ирээгүй цэргийн үүрэгтнийг эрэн сурвалжилж татлагаар оруулах бүх талын арга хэмжээ авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа М.Дэлгэрсайхан), Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Г.Чимэддавга) нарт;

е) Цэргийн албанд тэнцсэн иргэдийг тээвэрлэх автомашины техникин бүрэн бүтэн байдлыг хангулж зөвшөөрөл өгөх, жолооч нарт тээвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааны зааavarчилгаа танилцуулж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Г.Чимэддавга)-д;

ж) Цэргийн жинхэнэ алба хааж бэлтгэлээр халагдаж ирсэн цэргийн үүрэгтнүүдийг бүртгэж, ажлын байрны мэдээллээр хангаж, төрөл бурийн сургалтад хамруулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Чимэддорж-Ойдов), аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Т.Нарангарав) нарт тус тус даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ